



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

Зүүн хойд Азийн аялал жуулчлалын форум зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 37, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зүүн хойд Азийн аялал жуулчлалын 11 дэх удаагийн форумыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын холбоотой хамтран Улаанбаатар хотод 2015 оны 08 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Форумыг "Бизнес, хурал зөвлөгөөний аялал жуулчлал" сэдвийн дор явуулах, бүс нутгийн хотуудын төлөөлөгчдөд зориулсан нийслэлийн Засаг даргын нэрэмжит хүлээн авалт, бэсрэг наадам зохион байгуулах ажлыг Нью жуулчин турс ХХК-иар гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг ахлах мэргэжилтэн Д.Ганболдод даалгасугай.

3. Форум зохион байгуулахад шаардагдах төсвийн нийслэлд ноогдох зардал болох 10.000.000 /арван сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

